

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/199/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХҮМҮҮН ЦОГЦОЛБОР  
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно. ....	19
4.2 Төлбөрийн акт .....	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ОУБ	Олон улсын байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248. Факс: 70272582, Илгээлт: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/92  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**19020316**

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>276,688,860.59</u></b>	<b><u>315,442,175.09</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	276,688,860.59	315,442,175.09
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	276,688,860.59	315,442,175.09
35410	Бичиг хэргийн материал	1,809,157.80	523,420.40
35420	Аж ахуйн материал	1,221,872.20	271,800.00
35450	Барилгын засварын материал	415,211.32	221,400.00
35470	Бусад хангамжийн материал	273,242,619.27	314,425,554.69
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,842,157,399.91</u></b>	<b><u>5,812,422,686.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,842,157,399.91	5,812,422,686.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,861,357,399.91	4,829,345,264.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,660,206,248.00	4,821,153,283.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-374,899,325.96	-542,588,266.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	499,805,155.68	536,236,827.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,441,382.08	-198,777,997.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	276,819,307.29	299,692,570.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,997,257.81	-131,671,313.36
39217	Ном	44,864,654.79	45,300,159.79
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	980,800,000.00	983,077,422.00
39301	Програм хангамж	3,253,460.00	2,277,422.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,253,460.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	980,800,000.00	980,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,118,846,260.50</u></b>	<b><u>6,127,864,861.13</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,118,846,260.50</u></b>	<b><u>6,127,864,861.13</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,118,846,260.50	6,127,864,861.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,563,489,068.49	3,563,489,068.49
51101	Өмч: - төрийн	3,563,489,068.49	3,563,489,068.49
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-1,544,656,064.03	-1,535,637,463.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,544,656,064.03	-1,544,656,064.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,018,600.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,100,013,256.04	4,100,013,256.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,118,846,260.50</u></b>	<b><u>6,127,864,861.13</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,999,166,327.61</b>	<b>4,975,801,307.15</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,051,828,427.61</b>	<b>3,964,188,272.15</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	158,831,127.61	332,548,372.15	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	158,831,127.61	332,548,372.15	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	158,831,127.61	332,548,372.15	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	3,892,997,300.00	3,631,639,900.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,892,997,300.00	3,631,639,900.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>947,337,900.00</b>	<b>1,011,613,035.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	118,526,600.00	184,140,435.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,024,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,378,600.00	181,116,435.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	148,000.00	00.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	828,811,300.00	827,472,600.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	828,811,300.00	827,472,600.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,108,431,078.25</b>	<b>4,966,782,706.52</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,108,431,078.25</b>	<b>4,966,782,706.52</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,387,817,601.19	4,600,119,269.52	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,854,666,023.00	2,945,090,680.00	
210101	Үндсэн цалин	1,610,331,540.00	1,575,671,930.00	
210102	Нэмэгдэл	923,331,153.00	1,043,273,373.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,532,900.00	32,316,000.00	
210104	Урамшуулал	234,470,430.00	293,829,377.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	356,786,932.04	379,838,915.00	
210201	Тэтгэврийн даатгал	247,739,667.04	265,971,326.52	
210202	Тэтгэмжийн даатгал	28,509,567.00	29,386,708.72	
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,807,653.00	23,428,727.09	
210204	Ажилгүйдлийн даатгал	5,247,906.00	5,550,195.97	
210205	Эрүүл мэндийн даатгал	52,482,139.00	55,501,956.70	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	803,107,537.00	825,335,785.00	
210301	Гэрэл, цахилгаан	18,576,009.00	19,714,221.00	
210302	Түлш, халаалт	766,591,936.00	763,399,252.00	
210303	Цэвэр, бохир ус	17,939,592.00	42,222,312.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,695,855.60	11,511,206.28	
210401	Бичиг хэрэг	4,337,302.60	4,551,856.28	
210402	Тээвэр, шатахуун	603,600.00	768,300.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,472,536.00	1,964,770.00	
210404	Ном, хэвлэл	00.00	594,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	855,000.00	1,954,800.00	

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,427,417.00	1,676,980.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>44,847,417.90</b>	<b>66,404,079.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	318,100.00	807,700.00
210502	Хоол, хүнс	40,914,647.90	53,844,495.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,614,670.00	11,751,884.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,372,340.00</b>	<b>1,332,541.32</b>
210604	Урсгал засвар	4,372,340.00	1,332,541.32
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>266,900.00</b>	<b>3,140,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	266,900.00	3,140,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,240,490.00</b>	<b>00.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,240,490.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>308,834,105.65</b>	<b>367,466,062.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,684,853.00	23,132,089.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,969,818.00	6,407,119.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	283,179,434.65	337,926,853.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>720,613,477.06</b>	<b>366,663,437.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>172,351,268.00</b>	<b>294,860,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,969,500.00	143,263,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,812,200.00	76,928,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,983,400.00	71,909,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,586,168.00	2,759,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>548,262,209.06</b>	<b>71,803,037.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	548,262,209.06	71,803,037.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-109,264,750.64</b>	<b>9,018,600.63</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>111,079.60</b>	<b>00.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	111,079.60	00.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>33,299,026.24</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,299,026.24	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-33,187,946.64</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-142,452,697.28</b>	<b>9,018,600.63</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,563,489,068.49	3,845,550,971.84	-1,407,229,532.55	6,001,810,507.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,026,165.80	5,026,165.80
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,563,489,068.49</b>	<b>3,845,550,971.84</b>	<b>-1,402,203,366.75</b>	<b>6,006,836,673.58</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-142,452,697.28	-142,452,697.28
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,563,489,068.49</b>	<b>4,100,013,256.04</b>	<b>-1,544,656,064.03</b>	<b>6,118,846,260.50</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,563,489,068.49</b>	<b>4,100,013,256.04</b>	<b>-1,544,656,064.03</b>	<b>6,118,846,260.50</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,563,489,068.49</b>	<b>4,100,013,256.04</b>	<b>-1,544,656,064.03</b>	<b>6,118,846,260.50</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,018,600.63	9,018,600.63
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,563,489,068.49</b>	<b>4,100,013,256.04</b>	<b>-1,535,637,463.40</b>	<b>6,127,864,861.13</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,840,335,200.00</b>	<b>4,643,252,935.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,892,997,300.00</b>	<b>3,631,639,900.00</b>	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	3,892,997,300.00	3,631,639,900.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,892,997,300.00	3,631,639,900.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>947,337,900.00</b>	<b>1,011,613,035.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	118,526,600.00	184,140,435.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,024,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,378,600.00	181,116,435.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	148,000.00	00.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	828,811,300.00	827,472,600.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	828,811,300.00	827,472,600.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,810,731,610.00</b>	<b>4,614,405,622.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,810,731,610.00</b>	<b>4,614,405,622.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,090,169,486.94</b>	<b>4,245,508,685.00</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,854,685,202.00	2,945,090,731.00	
210101	Үндсэн цалин	1,461,949,587.00	1,519,396,138.00	
210102	Нэмэгдэл	1,207,949,907.00	1,098,687,422.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,680,000.00	43,627,196.00	
210104	Урамшуулал	143,105,708.00	283,379,975.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	356,703,107.04	379,838,864.00	
210201	Тэтгэврийн даатгал	243,815,424.14	265,040,830.79	
210202	Тэтгэмжийн даатгал	29,382,862.02	29,395,623.88	
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,731,326.98	23,422,199.25	
210204	Ажилгүйдлийн даатгал	5,523,932.51	5,634,719.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	55,249,561.39	56,345,491.08	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	805,296,955.00	825,335,785.00	
210301	Гэрэл, цахилгаан	18,576,009.00	19,714,221.00	
210302	Түлш, халаалт	768,781,354.00	763,399,252.00	
210303	Цэвэр, бохир ус	17,939,592.00	42,222,312.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,103,622.00	11,231,985.00	
210401	Бичиг хэрэг	1,067,590.00	2,945,515.00	
210402	Тээвэр, шатахуун	639,350.00	763,300.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,532,536.00	2,024,770.00	
210404	Ном, хэвлэл	52,200.00	643,900.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,000.00	1,962,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,316,946.00	2,892,000.00	

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,389,514.90	60,610,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	490,050.00	1,500,000.00
210502	Хоол, хүнс	40,333,934.90	51,610,995.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,565,530.00	7,499,975.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,267,330.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,267,330.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	266,900.00	3,140,000.00
210702	Дотоод албан томилолт	266,900.00	3,140,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,290,490.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,290,490.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,166,366.00	19,260,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,407,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,166,366.00	14,853,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>720,562,123.06</b>	<b>368,896,937.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	172,299,914.00	297,093,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,819,500.00	145,497,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,812,200.00	76,928,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,983,400.00	71,909,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,684,814.00	2,759,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	548,262,209.06	71,803,037.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	548,262,209.06	71,803,037.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>29,603,590.00</b>	<b>28,847,313.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>29,603,590.00</b>	<b>28,847,313.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,603,590.00</b>	<b>28,847,313.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	29,603,590.00	28,847,313.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,603,590.00	28,847,313.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-29,603,590.00</b>	<b>-28,847,313.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,459,112,500.00	4,387,309,463.00	71,803,037.00	98.39
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,459,112,500.00	4,387,309,463.00	71,803,037.00	98.39
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,310,354,400.00	4,239,052,563.00	71,301,837.00	98.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,989,438,100.00	2,945,090,731.00	44,347,369.00	98.52
210101	Үндсэн цалин	1,672,173,500.00	1,519,396,138.00	152,777,362.00	90.86
210102	Нэмэгдэл	1,064,944,600.00	1,098,687,422.00	-33,742,822.00	103.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,220,000.00	43,627,196.00	33,592,804.00	56.50
210104	Урамшуулал	175,100,000.00	283,379,975.00	-108,279,975.00	161.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	403,574,100.00	379,838,864.00	23,735,236.00	94.12
210201	Тэтгэврийн даатгал	283,996,500.00	265,040,830.79	18,955,669.21	93.33
210202	Тэтгэмжийн даатгал	29,894,300.00	29,395,623.88	498,676.12	98.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,915,500.00	23,422,199.25	493,300.75	97.94
210204	Ажилгүйдлийн даатгал	5,978,800.00	5,634,719.00	344,081.00	94.24
210205	Эрүүл мэндийн даатгал	59,789,000.00	56,345,491.08	3,443,508.92	94.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	826,472,600.00	825,335,785.00	1,136,815.00	99.86
210301	Гэрэл, цахилгаан	17,906,600.00	19,714,221.00	-1,807,621.00	110.09
210302	Түлш, халаалт	766,591,900.00	763,399,252.00	3,192,648.00	99.58
210303	Цэвэр, бохир ус	41,974,100.00	42,222,312.00	-248,212.00	100.59
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,860,200.00	10,858,850.00	1,350.00	99.99
210401	Бичиг хэрэг	1,263,600.00	1,263,580.00	20.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	708,500.00	763,300.00	-54,800.00	107.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,035,400.00	2,024,770.00	10,630.00	99.48
210404	Ном, хэвлэл	852,700.00	852,700.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,962,500.00	37,500.00	98.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	3,992,000.00	8,000.00	99.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	61,439,000.00	59,910,970.00	1,528,030.00	97.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800,000.00	800,000.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	53,139,000.00	51,610,995.00	1,528,005.00	97.12
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,500,000.00	7,499,975.00	25.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	669,000.00	116,000.00	553,000.00	17.34
210702	Дотоод албан томилолт	669,000.00	116,000.00	553,000.00	17.34
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16901400.00	16901363.00	37.00	100.00

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,407,300.00	4,407,300.00	00.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,494,100.00	12,494,063.00	37.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	148758100.00	148256900.00	501,200.00	99.66
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	148,758,100.00	148,256,900.00	501,200.00	99.66
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	145,996,600.00	145,497,000.00	499,600.00	99.66
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,761,500.00	2,759,900.00	1,600.00	99.94
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,459,112,500.00	4,387,309,463.00	71,803,037.00	98.39
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,631,639,900.00	3,560,973,678.00	70,666,222.00	98.05
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,631,639,900.00	3,560,973,678.00	70,666,222.00	98.05
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	827,472,600.00	826,335,785.00	1,136,815.00	99.86
132001	Орон нутгийн төсвөөс	827,472,600.00	826,335,785.00	1,136,815.00	99.86
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	195.00	195.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	141.00	141.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	53.00	53.00	00.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>184,140,435.00</b>	<b>184,140,435.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>184,140,435.00</b>	<b>184,140,435.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	35,303,435.00	35,303,435.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,981,935.00	1,981,935.00
210401	Бичиг хэрэг	1,681,935.00	1,681,935.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	700,000.00	700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	700,000.00	700,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,024,000.00	3,024,000.00
210702	Дотоод албан томилолт	3,024,000.00	3,024,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29597500.00	29597500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,597,500.00	29,597,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	148837000.00	148837000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	148,837,000.00	148,837,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,928,000.00	76,928,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	184140435.00	184140435.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	184,140,435.00	184,140,435.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,024,000.00	3,024,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	181,116,435.00	181,116,435.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал, Э.Батчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль нь танхимын болон цахим сургалтыг чанартай зохион байгуулах замаар сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах, “Хөгжсөн багшаас-Чадварлаг сурагч” хөтөлбөрийг чанар үр дүнтэй хэрэгжүүлэх, ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх, дэлхийд өрсөлдөх чадвартай иргэнийг бүртгэхийг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүмүүн цогцолбор сургуулийн захирлын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/06 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн байгуулах тухай” ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 2021- 2022 оны хичээлийн жилийн төлөвлөгөөнд 11 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөн, дотоод хяналт шалгалтын үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнасан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг байна. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 4,459,112.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 66,886.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 50,165.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 4,459,112.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 184,140.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 4,614,405.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 170,005.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 102,254.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 33,218.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 435.5

мянган төгрөгийн ном, 2,277.4 мянган төгрөгийн программ хангамж, нийт 308,192.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28,847.3 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 279,344.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 53,203.5 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 234,168.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 248,618.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

#### **Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 315,442.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 5,812,422.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	276,688.86	315,442.18	38,753.32
Үндсэн хөрөнгө	5,842,157.40	5,812,422.69	(29,734.71)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,118,846.26</b>	<b>6,127,864.86</b>	<b>9,018.60</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,118,846.26	6,127,864.86	9,018.60
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,118,846.26</b>	<b>6,127,864.86</b>	<b>9,018.60</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 315,442.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 38,753.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,812,422.7 мянган төгрөг болж 29,734.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,127,864.9 мянган төгрөг болж 9,018.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 4,788,900.0 мянган төгрөгөөр төлөвлөн, нийт зардалд 4,788,900.0 мянган төгрөгийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 329,787.5 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар бууруулж, 4,459,112.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 4,459,112.5 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 4,387,309.5 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 71,803.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,387,309.5 мянган төгрөг буюу 98.4 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 184,140.4 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний зардалд 35,303.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 148,837.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бараа материалын дансанд 53,203.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бүртгэснээс БСШУЯ-аас 3,156.9 мянган төгрөгийн, БСУГ-аас 11,974.1 мянган төгрөгийн, Дэлхийн зөн ОУБ-аас 3,472.2 мянган төгрөгийн, БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар 29,635.3 мянган төгрөгийн, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3,295.0 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 1,670.0 мянган төгрөгийн бараа материалын орлого байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 12 дугаар тогтоолыг үндэслэн цаашид ашиглах боломжгүй болсон 9,058.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Тайлант хугацааны худалдан авалтыг и-баримттай тулгахад харилцагч байгууллагатай хийсэн 178,158.8 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүйг завсрын аудитаар илрүүлж, жилийн эцсээр зөрчлийг арилган ажилласан.

### **3.8 Аудитын гол асуудал**

Бараа материалын дансанд 14 нэр төрлийн 6,866.4 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,276.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 6,866.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,866.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

##### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

##### **4.3 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй.

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд 14 нэр төрлийн 6,866.4 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж байх

#### **2. Шилэн данстай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д / д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль	2	6,866.4	-	-	-	-	-	-	2	6,866.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)